



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 1/19

Өлгий

**Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай**

Усны тухай хуулийн 28.6 заалт, Хар нуур- Ховд голын сав газрын захиргааны даргын 2022 оны 05-р сарын 09-ны өдрийн дугаар 16 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Усны тухай хуулийн 28-ийн 6 дахь заалтыг үндэслэн “Эйш кей би интернэйшнэл холдинг ХХК-д Өлгий хотыг тойрон гарах авто зам төмөр бетон гүүр барихад шаардлагатай 8892 м<sup>3</sup> усыг нэг жилийн хугацаагаар ашиглах зөвшөөрөл олгосугай.

2. Усны тухай хуулийн 29.1, 18.1.4 дэхь заалтыг үндэслэн “Эйш кей би интернэйшнэл холдинг ХХК –тай ус ашиглах гэрээ байгуулж ажиллахыг БОАЖГ-ын мэргэжилтэн Б.Гүлжанд үүрэг болгосугай.

3. Усны тухай хуулийн 30 дугаар зүйл дэхь заалтуудын дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ тайланг дараа оны 1-р улиралд багтаан ирүүлэхийг “Эйш кей би интернэйшнэл холдинг ХХК -ны гүйцэтгэх захирал /ЖАН ХАОРАН /-д даалгасугай

4. Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Өлгий сумын байгаль хамгаалагч А.Дамысбек, Х.Сулушаш нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.МАРАТ